



ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.09.28 № 328
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030653


Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Есөнзүйл сумын Монгол Ардын Намын Хорооны тэргүүлэгчдийн
2020 оны 06-р сарын 20-ны өдрийн хуралдааны 20-р тогтоолын хавсралт



**ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.06.20

Мөнхбулаг

**НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ - АЖИЛ, ОРЛОГОТОЙ ИРГЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЖ
ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫГ ЭРЧИМТЭЙ ХӨГЖҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙНӨСӨЛТИЙГ
НЭМЭГДҮҮЛЭН АЖИЛЛАНА**

1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ-ХӨГЖЛИЙН ГАРЦ

1.1.1. Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, ноос, ноолуурыг уламжлалт технологи болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулах

1.1.2. Махны чиглэлийн үүлдрийн мал өсгөх бодлогыг дэмжиж, мал нядалгааны цэг байгуулж, малын дотор дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж борлуулах жижиг үйлдвэр байгуулж малчдын мах борлуулах орлогыг нэмэгдүүлнэ.

1.1.3. Сүү боловсруулах цех байгуулж, малчид иргэдийн сүү, цагаан идээ боловруулж аймаг хотын зах зээлд гаргах идэвхийг дэмжиж ажиллана.

1.1.4. Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж шинэчлэл хийх, тариалангийн бүс нутгуудад услалтын систем байгуулж, хүнсний ногооны төрөлжсөн зоорь, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногоог боловсруулах, даршлах савлах, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, сумын газар тариалангийн талбайг хашаажуулах.

1.1.5. Сумын хэмжээнд нийт 2500 гаталбайг үр тариа, төмс хүнсний ногоо, малын тэжээл тариалах, шинээр 1000 га газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.

1.1.6. Өрхийн тариаланг хөгжүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангах

1.2 ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ СУМААС ЭХЭЛНЭ

1.2.1. Бие даан хөгжих эдийн засаг, төсөв санхүү, байгаль орчин, хүний нөөцийн эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

1.2.2. Цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон, аж ахуй нэгж, айл өрхийг холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3. Өндөр гэгээний өвгөн суварга төрсөн газар цэцэрлэгт хүрээлэн 1-р багийн төвийг цахилгаан эрчим хүчээр хангах

1.2.4. Суманд худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлийн томоохон аж ахуй нэгж байгуулах санаачилгыг дэмжиж, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, сумын хөгжлийн сан болон сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх.

1.3. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ

1.3.1. Аялал жуулчлалыг Сумын тэргүүлэх салбарын нэг болгон Өндөр гэгээний төрсөн газар Мандаа толгой, Буурлын хөшөө, Өвгөн суварга, Наран толгой, Цагаан Толгой, Жонон Вангийн хэрэм, Сэрүүн булаг, Номын Өргөө зэргээг аялуулах жуулчдын тоог өсөн нэмэгдүүлнэ.

1.3.2. Сумын төвд 2.5 км хатуу хучилттай зам тавих мөн Сумын төвөөс улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбоно.

1.3.3. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн хийж, инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр

хорооллуудын гудамж талбайн хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.4.1. Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болгох.

1.4.2. Сумын нийт мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, чанартай малтай малчдыг урамшуулах тогтолцоог бий болгох, залуу малчдыг бэлтгэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх.

1.4.3 Нийтийн орон сууцтай болгон залуу боловсон хүчнийг ажилж амьдрах таатай орчин нөхцлийг бий болгоно.

1.4.4. Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, фонд засварлах

1.4.5. Бэлчээрийг бордох, олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

1.4.6. Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах.

1.4.7. Нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

1.4.8. Олон гишүүнтэй хамтын хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлж улмаар хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл- үйлчилгээг бий болгож ажлын байрыг нэмэгдүүлнэ

1.4.9. Ажлын байр нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч, 250-аас доошгүй түр болон бүр ажлын байр бий болгох, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 300 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгох.

1.4.10. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх.

1.5. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай

1.5.1. Ногоон хөгжлийн цогц хөтөлбөр гарган, эко загвар сум бий болгох ажлыг эхлүүлнэ.

Иргэдээ боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын үйлчилгээнд адил тэгш, хүртээмжтэй хамрагдах нөхцлийг бүрдүүлж, хүүхэд, гэр бүлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО-ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.1. Эрүүл иргэн-Нийгмийн үнэт баялаг



Handwritten signatures and a number 25.

2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчигээг эрүүл мэндийн байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.1.2. Эрүүл мэндийн төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж зөөлөн эдлэлээр бүрэн хангаж, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлж, аймаг, хотод эмчлүүлэгчдийн тоог бууруулна.

2.1.3. Эмнэлэгийн хуучин байрыг их засварт оруулах.

2.1.4. Гүн өрмийн худаг гаргаж цэвэр бохир шугаманд холбох, ногоон байгууламжийг нэмэгдүүлж тохилог орчин бүрдүүлэх

2.1.5. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил төрийн бус байгууллагыг дэмжиж ажиллана.

2.1.6. Эрүүл мэндийн төвийн ажилчин, албан хаагчдыг ажиллах бололцоо нөхцөлөөр хангаж техник хэрэгсэлийг шинэчилнэ.

2.2. Боловсрол төлөвшил-хүний үнэт зүйл

2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоглоомын талбайг тохижуулах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх, орчин үеийн тоглоомоор хангаж хүүхдийн сурч хөгжиж таатай орчинг бүрдүүлнэ.

2.2.2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл шинэчлэх, мөн ногоон байгууламжийг нэмэгдүүлж эко орчин бий болгоно.

2.2.3. Ерөнхий боловсролын сургуулийг байгалийн ухааны, сэтгэн бодох техникийн сэтгэлгээг хөгжүүлэх эрэгтэй дизайн технологийн кабинетаар ханган "Оюунлаг Монгол хүүхэд", "Сайн хичээл" аймгийн хөтөлбөрийг боловсруулан, "Шатар" хөтөлбөр үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх.

2.2.4. Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол, ур чадварыг дэмжсэн "Бүтээлч багш" хөтөлбөрийг хэрэгжүүлж, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, тэдний нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэхэд анхаарах.

2.2.5. Соёлын төвийн уран зургийн галерейд орон нутаг судлах танхимын ажилтантай болох

2.2.6. Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өргөжүүлж, биеийн тамир спортыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.2.7. Орон нутаг судлах танхим галерейн аюулгүй байдлыг хангаж цонхны хаалт хамгаалалт, камержуулах багш ажилчдыг ажиллах бололцоо нөхцлөөр хангах, ногоон байгууламж нэмэгдүүлж эко орчин бий болгон тохижуулах

2.3. Гэр бүлийн хөгжил-нийгмийн хамгаалал

2.3.1. Залуучуудыг амьдралын зөв дадалд сургах, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, амралт, чөлөөт цагийн чиглэл бүхий "Залуучуудын хөгжлийн төв"-ийг байгуулна.

2.3.2. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмадын өргөөний гадна талыг тохижуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.

2.3.3. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээг төрөөс иргэдэд шуурхай, хүртээмжтэй, шударга, ялгамжгүй үйлчилдэг тогтолцоог бий болгоно.



Гурав. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээ

3.1. Төрийн үйлчилгээ иргэн танд

- 3.1.1. Есөнзүйл сумын ЗДТГ-ын конторын барилгыг шинээр барих
- 3.1.2. Багийн төвийн ажлын байрны ашиглалтыг сайжруулж засварлах, багийн дарга нарыг унаагаар хангах.
- 3.1.3. Төрийн худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй явуулж, төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтанд хамруулсан байна
- 3.1.4. Багийн иргэдийн Нийтийн хурлын үйл ажиллагааг тогмолжуулах, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгоно.
- 3.1.5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.
- 3.1.6. Төрийн үйлчилгээг шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилтэт хэлбэрийн үйлчилгээг тууштай нэвтрүүлж, төрийн албаны хяналтын сүлжээг бий болгож, төрийн байгууллагуудыг салбар дундын цахим сүлжээнд бүрэн нэгтгэж, иргэдийн тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болгоно.
- 3.1.7. Төрийн байгууллагын бүх салбарт хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг ашиг сонирхолын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ
- 3.1.8. Иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтыг хуулийн дагуу явуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулж иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэн, зөвлөн туслах үйлчилгээг нэмэгдүүлнэ.

3.2. Хууль эрх зүй, аюулгүй амьдрал

- 3.2.1. Хүний эрх, үүргийн нэгдлийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, эрх зүйн туслалцааны бие даасан үйлчилгээг бий болгох.
- 3.2.2. Орон нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрх, эрх чөлөө, иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахын өмнө иргэд, хуулийн этгээд, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тэдгээрээс гаргасан саналуудыг тухайн гарах шийдвэрт тусгаж, эргэн мэдээлэх асуудлыг журамлаж хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Суманд бүртгэл мэдээллийн онлайн системийг бүрэн нэвтрүүлснээр иргэний, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь чирэгдэлгүй үзүүлэх боломжтой болно.
- 3.2.4. Гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, дэлхий нийтийн үнэт зүйл, монгол ёс зан заншил, ухамсрыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэн зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.5. Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулж, орон байрын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

